



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,  
3 дугаар бай. Орон нутгийн өмчийн III байр.  
Утас: (705) 2-27-34  
Вэб сайт: dorongovi@audit.gov.mn

2020. 04. 22 № 1-6/396

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Г ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГА Т.ЭНХТҮВШИН ТАНАА**

Аймгийн Төрийн аудитын газрын 2020 оны  
гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Төсвийн  
өрөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн  
нэгтгэсэн тайланд аудит хийж дуусган аудитын  
тайланг хүргүүлж байна.

Санхүүгийн аудитын тайлангаар өгсөн  
зөвлөмжийг хэрэгжүүлэн, биелэлтийг хариуг 2020  
оны 09 дүгээр сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Хавсралт: 30.. хуудастай

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Ч.АРИУНАА

010030129

My. Dok. D. toot 2020



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/1/СТА-ТЕЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа Утас: 70522734 Цахим хаяг: ariunaa.ch@audit.gov.mn Аудитын менежер: Ч.Хэрлэнчимэг Утас: 70503020 Цахим хаяг: kherlenchimegch@audit.gov.mn Ахлах аудитор: О.Нарангараав Утас: 70523020 Цахим хаяг:narangarav.o@audit.gov.mn Аудитор: У.Оюунтулхүүр Утас: 70523020 Цахим хаяг:oyuntulkhuur.u@audit.gov.mn Аудитор: Б.Уранбилэг Утас: 70523020 Цахим хаяг:uranbileg.b@audit.gov.mn Аудитор: Т.Мөнхтогтох Утас: 70523020 Цахим хаяг:munkhtogokht@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	3
2. Аудитын тайлан .....	5
2.1. Оршил .....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, ЖУРАМ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ .....	6
2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	6
2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	7
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	7
2.8.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө .....	8
2.8.2 Авлага .....	9
2.8.3 Урьдчилгаа .....	10
2.8.4 Бараа материал .....	10
2.8.5 Үндсэн хөрөнгө .....	11
2.8.6 Урт хугацаат зээл .....	12
2.8.7 Өр төлбөр .....	13
2.8.9 Засгийн газрын хувь оролцоо .....	13
2.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	14
2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	16
2.11. Шилэн дансны мэдээлэл .....	16
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	17
2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	17
2.14. Аудитын зөвлөмж .....	18
3. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	20
3.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан .....	20
3.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан .....	23
3.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	27
3.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	32
3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	33
3.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	36
4. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	0



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,  
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,  
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: [dornogovi@audit.gov.mn](mailto:dornogovi@audit.gov.mn)

2020. 04. 22 № 1-6/397

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГА Т.ЭНХТҮВШИН  
ТАНАА**

Аудитын гэрчилгээ

Монгол улсын Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Дорноговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь 2019 оны жилийн эцсийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуванс.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Дорноговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.АРИУНАА

## 2. Аудитын тайлан

### 2.1. ОРШИЛ

Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг аймгийн Засаг дарга Т.Энхтувшин танд танилцуулж байна.

Энэхүү тайландаа үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дунд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хулээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аudit хийлээ.

Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 04 дүгээр сарын 01-ээс 2020 оны 04 дүгээр сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын Санхүүгийн аудитын алба хариуцаж хэрэгжүүлэв.

Аймгийн ТЕЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 03 дугаар сарын 31-ны өдрийн 3/554 дүгээр албан бичгээр 2020 оны 03 дугаар сарын 31-ний өдөр ирүүлсэн байна.

Залруулга хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 1/684 тоот албан бичгээр 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр эцэслэж ирүүлсэн.

## 2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалыаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бodoх бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

## 2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дорноговь аймгийн ТЕЗ-ийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Хүн амын ая тухтай орчин нөхцөл бүрдсэн орон нутгийн түүхий эд, санхүүгийн нөөц боломжид тулгуурласан, дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг татан байгальд ээлтэй дэвшилтэй технологи бүхий экспортын баримжаатай боловсруулах аж үйлдвэр, жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэн, эдийн засгийг олон талтай болгож, мэдлэгт суурилсан эдийн засгийг тэнцвэртэй төлөвшүүлэн хөгжүүлэх”.

Дорноговь аймгийн ТЕЗ-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төсвийн тухай хуульд заасны дагуу сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын үйлчилгээ, эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, газрын харилцаа, кадастр, хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээг орон нутагт хэрэгжүүлэхэд зориулсан санхүүжилтийг тусгай зориулалтын шилжүүлгээр орон нутгийн төсөвт тусгах
- Орон нутаг дахь соёл, урлаг, нийтийн биеийн тамирын чиг үүргийг орон нутаг бие даан хэрэгжүүлэх
- Өмчийн ашиглалт, хамгаалалт, үр ашгийг сайжруулах зорилгоор сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн төвийн байр ашиглалттай холбоотой зардлыг орон нутаг хариуцах
  - Агаарын бохирдлыг бууруулах
  - Хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээнд хөрөнгө төлөвлөж хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах
  - Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгогдох орлогын шилжүүлгээс хот тохижилтийн зардлын тодорхой хувь, мал эмнэлгийн үйлчилгээний зардлыг санхүүжүүлэх
  - Соёл урлагийн байгууллагуудын үйл ажиллагааны орлогыг салбарын ажилчдын нийгмийн баталгааг хангахад зарцуулах боломж олгох зэрэг зарчмуудыг тусгасан.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2019 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 74 дүгээр тушаалаар “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бodoх бүртгэлд тусгах, хяналт тавих” журам шинэчлэн батлагдсан.
- Засгийн газрын 2019 оны 88 дугаар тогтоолоор Санхүүгийн алба байгуулах тухай” Засгийн газрын 2014 оны 326 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Санхүүгийн албаны зохион байгуулалт, чиг үүрэг, орон тооны жишиг норматив”-ын зарим заалтад өөрчлөлт оруулсан.

- Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам” шинэчлэн батлагдсан.

## 2.5 Нягтлан бodoх бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бodoх бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Дорноговь аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бodoх бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын дагуу боловсруулагдсан байна.

Дорноговь аймгийн ТЕЗ-ийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Дорноговь аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2019 онд төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа орон нутаг дахь 40 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, санхүү, нягтлан бodoх бүртгэлийн чиглэлээр 426 зөвлөмж өгсөнд шалгагдагч байгууллагуудаас зөвлөмжийн хэрэгжилтийг заасан хугацаанд ирүүлсэн байна.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дорноговь аймгийн ТЕЗ-ийн бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 9 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 9 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нэгтгэсэн санхүүгийн тайлангийн цэвэр хөрөнгийг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшинг цэвэр хөрөнгийн дүн болох 169,258.9 сая төгрөгийн 1 хувь буюу 1,692.6 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшинг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно. Учир нь төлөвлөлтийн үе шатанд тооцсон материаллаг байдлын түвшинг жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлтийг сонгон авсантай холбоотой юм.

## 2.8 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн

### 2.8.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 4,117.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 5,410.5 сая төгрөг болж, 1,293.3 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №1 Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	9.44	2.36	(7.08)
Банкинд байгаа бэлэн мөнгө	4,107.75	5,408.17	1,300.42
Замд яваа мөнгөн хөрөнгө	-	-	-
Хадгаламж	-	-	-
<b>Дүн</b>	<b>4,117.19</b>	<b>5,410.53</b>	<b>1,293.34</b>
<b>Үүнээс, байгууллагын төрлөөр</b>			
Төсөвт байгууллага	90.37	185.27	94.9
Төсөл/ сан	1,562.45	1,401.58	-160.87
Төрийн сан	1,492.03	2,858.60	1,366.57
ТӨҮГ болон ОНӨҮГ	972.34	965.08	-7.26
<b>Дүн</b>	<b>4,117.19</b>	<b>5,410.53</b>	<b>1,293.34</b>

Эх сурвалж: Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Касст байгаа бэлэн мөнгөний 2.4 сая төгрөгийн үлдэгдэл нь ОНӨААН-ийн үлдэгдэл байна.

Банкинд байршиж буй 5,408.2 сая төгрөгөөс төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл 4,441.6 сая төгрөг, арилжааны банк дахь харилцах дансны үлдэгдэл 966.6 сая төгрөг байна. Үүнээс 162.2 сая төгрөг төсөвт байгууллагын ахмадын сангийн, 962.7 сая төгрөг орон нутгийн өмчит байгууллагын, 4,283.3 сая төгрөг нь төрийн сангийн үлдэгдэл байна.

### Төрийн сангийн мөнгөн хөрөнгө

Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 3,139.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 4,441.6 сая төгрөг болж, 1,301.5 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №1-1 Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа мөнгөн хөрөнгө	4,107.75	5,408.17	1,300.42
Төгрөг	4,107.75	5,408.17	1,300.42
Төрийн сан	3,139.82	4,441.57	1,301.75
Монгол банк	-	-	-
Арилжааны банк	967.92	966.60	(1.32)
Гадаад валют	-	-	-
Монгол банк	-	-	-
Замд яваа хөрөнгө	-	-	-
<b>Нийт дүн</b>	<b>4,107.75</b>	<b>5,408.17</b>	<b>1,300.42</b>

Эх сурвалж: Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төрийн сангийн эхний үлдэгдэл 1,376.9 сая төгрөгөөс тайлант онд 204.4 сая төгрөгийг орон нутгийн төсвийн урсгал зарлагыг санхүүжүүлэхэд, 500 сая төгрөгийг он дамжин хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд, 672.5 сая төгрөгийг тайлант оны хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээнд нийт 1,376.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

Тайлант онд орон нутгийн төсвийн орлогоор 32,575.2 сая төгрөг бүрдүүлж, 124.1 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, 16,696.2 сая төгрөгийг харьяа байгууллагуудын урсгал санхүүжилтэд, тусгай шилжүүлгийн болон соёлын байгууллагын байр ашиглалттай

холбоотой зардалд 5,692.7 сая төгрөгийг санхүүжүүлж, 7,844.9 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын санхүүжилтэд, 753.3 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтэд тус тус зарцуулжээ.

Замын-Үүд сумын төсвөөс 3,962.2 сая төгрөгийг аймгийн төсөвт татан төвлөрүүлж, бусад сумдад 5,592.6 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгосон байна.

#### Аудитын илрүүлэлт:

- Дэлгэрэх сумын Засаг даргын тамгын газрын дарга болон төрийн сангийн мэргэжилтний гарын үсэг, тамга тэмдэггүй төлбөрийн хүсэлтээр 23.9 сая төгрөгийн, 9.1 сая төгрөгийн гүйлгээний төлбөрийн хүсэлт анхан шатны баримтгүй ажил гүйлгээг хийсэн байна.
- Аяраг, Хатанбулаг, Хөвсгөл сумдын ЗДТГ нь нэмэлт санхүүжилтийн дансаар цргэн хуулийн этгээдээс нийт 148.5 сая төгрөгийн хандив санхүүгийн туслалцаа авсан байна
- Аймгийн ЗДТГ-ийн нэмэлт дансанд цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийн орлого нийт 79,802.5 мянган төгрөг төвлөрч, түүний 50 хувь болох 39,901.2 мянган төгрөгийг Сангийн яамны Төрийн сангийн дансанд төвлөрүүлэхээс 12,901.2 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна.

#### 2.8.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 7,377.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 5,951.7 сая төгрөг болж, 1,425.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	41.12	17.08	(24.04)
Төлбөртэй үйлчилгээний авлага	3.76	0	(3.76)
Татаас, санхүүжилтийн авлага	50.58	6.7	(43.88)
Зээлийн хүүгийн авлага	43.03	81.71	38.68
Дансны авлага /ОНӨҮГ/	3,068.08	1,915.54	(1,152.54)
Татвар, НДШ-ийн авлага /ОНӨҮГ/	20.71	9.44	(11.27)
Бусад авлага	623.78	316.68	(307.1)
Зээлийн авлага	3,526.22	3,604.60	78.38
<b>Дүн</b>	<b>7,377.28</b>	<b>5,951.74</b>	<b>(1,425.54)</b>
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	3,719.93	3,730.85	10.92
Төсөл/ сан	434.29	268.32	(165.97)
Төрийн сан	113.93	0.43	(113.5)
ОНӨҮГ	3,109.13	1,952.14	(1,156.99)
<b>Дүн</b>	<b>7,377.28</b>	<b>5,951.74</b>	<b>(1,425.54)</b>

Эх сурвалж: Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт авлагын дүнд ажилчидтай холбоотой авлага 17.1 сая төгрөг буюу 0.3 хувийг, татаас санхүүжилтийн авлага 6.7 сая төгрөг буюу 0.1 хувийг, зээлийн авлага 3,604.6 сая төгрөг буюу 59.6 хувийг, ОНӨҮГ-ын татвар, НДШ-ийн авлага 1,925.0 сая төгрөг буюу 31.8 хувийг, зээлийн хүүгийн авлага 81.7 сая төгрөг буюу 1.4 хувийг, бусад авлага 316.7 сая төгрөг буюу 6.8 хувийг тус тус эзэлж байна.

Зээлийн авлагын үлдэгдэл 3,604.6 сая төгрөг, үүнээс 3,544.6 сая төгрөг нь сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага, 60.0 сая төгрөг нь ЖДҮС-аас хувийн хэвшилд олгосон зээлийн авлага байна.

Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагын 50.7 хувь буюу 1,797.1 сая төгрөг нь хугацаа хэтэрсэн зээл байна.

Аудитын илрүүлэлт:

- Дэлгэрэх, Сайхандулаан сумд нь сум хөгжүүлэх сангийн 294.7 сая төгрөгийн зээлийн үлдэгдлийг зээлдээгч нартай тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

### 2.8.3 УРЬДЧИЛГАА

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 63.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 1,163.2 сая төгрөг болж, 1,100.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	45.06	999.42	954.36
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	10.99	156.82	145.83
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	6.92	6.92	0.00
Цалингийн урьдчилгаа	0.00	0.00	0.00
Томилолтын урьдчилгаа	0.00	0.00	0.00
<b>Дүн</b>	<b>62.97</b>	<b>1,163.16</b>	<b>1,100.19</b>
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	11.43	77.01	65.58
Төсөл/ сан	40.55	20.55	-20.00
Төрийн сан	0.00	908.78	908.78
ОНӨҮГ	10.99	156.82	145.83
<b>Дүн</b>	<b>62.97</b>	<b>1,163.16</b>	<b>1,100.19</b>

Эх сурвалж: Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэлд 2019 онд үүссэн 1,145.2 сая урьдчилж гарсан зардал, бараа ажил, үйлчилгээний төлбөрүүд байна Үүнд:

- Сургуулийн сантехникийн болон шалны урсгал засварын урьдчилгаа зардал 70.1 сая төгрөг
- ОНХС болон орон нутгийн хөрөнгө оруулалтын урьдчилгаа санхүүжилт 929.4 сая төгрөг
- ОНӨААН-ийн бараа материал бэлтгэх урьдчилгаа 145.8 сая төгрөг

Аудитын илрүүлэлт:

- Сайншанд сумын Зүүнбаян багийн 4 дүгээр сургууль 2019 онд гүйцэтгэл нь гараагүй байхад төсвөөс 20.8 сая төгрөгийг шилжүүлж, зардлаар бүртгэснийг аудитын явцад залруулан, албан шаардлага өгсөн байна.

### 2.8.4 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 6,442.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 8,011.0 сая төгрөг болж, 1,568.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	825.1	1,150.4	325.3
Тусгай зориулалтын материал	783.7	953.3	169.6
Эм боох материал	41.3	197.1	155.8
Бэлэн бүтээгдэхүүн	417.1	544.0	126.9

<b>Хангамжийн материал</b>	<b>5,052.8</b>	<b>6,156.7</b>	<b>1,104.0</b>
Бичиг хэргийн материал	158.9	224.5	65.6
Аж ахуйн материал	3,154.3	3,531.9	377.6
Сэлбэг хэрэгсэл	54.9	66.2	11.3
Түлш шатах тослох материал	196.2	243.8	47.6
Барилгын засварын материал	37.1	26.5	(10.7)
Хүнсний материал	185.2	228.5	43.2
Бусад хангамжийн материал	1,266.1	1,835.6	569.5
<b>Мал амьтад</b>	<b>123.1</b>	<b>137.2</b>	<b>14.1</b>
<b>Нөөцийн бараа</b>	<b>24.1</b>	<b>22.7</b>	<b>(1.4)</b>
<b>Дүн</b>	<b>6,442.2</b>	<b>8,011.0</b>	<b>1,568.8</b>
<b>Үүнээс, байгууллагын төрлөөр</b>			
Төсөвт байгууллага	5,383.3	6,811.4	1,428.1
Төсөл/ сан	-	-	-
Төрийн сан	-	-	-
ТӨҮГ болон ОНӨҮГ	1,058.9	1,199.6	140.7
<b>Дүн</b>	<b>6,442.2</b>	<b>8,011.0</b>	<b>1,568.8</b>

Эх сурвалж: Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд харьяа төсөвт байгууллагууд 13,629.8 сая төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдан авч, УТХО болон ОНТХО, хандив тусламж, үнэ төлбөргүйгээр 1,380.8 сая төгрөгийн, данс хооронд болон балансаас балансад 149.7 сая төгрөгийн бараа материалыг шилжүүлэн авсан бөгөөд бараа материал нийт дүнгээрээ 15,160.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Мөн 13,170.4 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, балансаас шилжүүлсэн болон акталж устгасан 421.1 сая төгрөг, нийт 13,591.5 сая төгрөгийн бараа материалыг данс бүртгэлээс хассан байна.

#### Аудитын илрүүлэлт:

- Төвийн шууд захирагчид ТБОНӨХБАУХАТХ-ийн холбогдох заалтыг зөрчиж худалдан авалт хийсэн.
- Зарим төсвийн байгууллагууд бараа материалын үлдэгдэлд тооллого хийгээгүй.
- Айраг сумын ЗДТГ нь уул уурхайн компаниас 14.1 сая төгрөгийн хөрөнгө хандив тусламж авсан байна.
- Аймгийн ИТХ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын төсвөөс Прокурорын газарт 3,200.8 мянган төгрөгийн проектор, Улсын бүртгэлийн хэлтэст 1,816.1 мянган төгрөгийн камер, төлөөлөгчдийн тойрогт ажиллах зардлын төсвөөс Хөвсгөл сумын Цэцэрлэг, Соёлын төөвд тус бүр нь 1250.0 мянган төгрөгийн үнэтэй 2 ширхэг notebook авч өгсөн байна. Хөрөнгүүдийг тухайн байгууллагуудад биетээр хүлээлгэн өгсөн боловч байгууллагууд хөрөнгийг дансанд бүртгээгүй, мөн ИТХ-ын нягтлан бодох бүртгэлд нийт 7,516.9 мянган төгрөгийн хөрөнгийг балансын дансанд үлдэгдлээр тайлагнасан байна.

#### 2.8.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 139,638.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 152,776.0 сая төгрөг болж, 13,137.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Биет хөрөнгө</b>	<b>130,410.9</b>	<b>143,427.1</b>	<b>13,016.2</b>
Барилга, байгууламж, орон сууц	103,325.9	116,641.3	13,315.4
Хуримтлагдсан элэгдэл	(4,271.9)	(8,379.6)	(4,107.7)
Авто-тээврийн хэрэгсэл	8,036.8	10,127.4	2,090.5
Хуримтлагдсан элэгдэл	(4,742.6)	(5,600.0)	(857.4)

Машин тоног төхөөрөмж(компьютер)	17,282.7	17,944.1	661.4
Хуримтлагдсан элэгдэл	(9,665.2)	(10,288.4)	(623.2)
Тавилга, аж ахуйн эд хогшил	5,814.5	6,606.2	791.7
Хуримтлагдсан элэгдэл	(3,149.5)	(3,476.5)	(327.0)
Зам, гүүрийн байгууламж	4,143.1	4,330.9	187.8
Хуримтлагдсан элэгдэл	(252.3)	(639.1)	(386.7)
Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	0.0	0.0	-
Хуримтлагдсан элэгдэл	(0.0)	(0.0)	-
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	703.2	708.0	4.8
Бусад үндсэн хөрөнгө	19,579.4	22,166.1	2,586.7
Хуримтлагдсан элэгдэл	(7,178.3)	(8,652.8)	(1,474.5)
Дуусаагүй барилга, байгууламж	167.6	1,150.5	982.9
Ном	617.6	788.9	171.4
<b>Дүн</b>	<b>139,638.3</b>	<b>152,776.0</b>	<b>13,137.8</b>
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	110,856.5	124,620.5	13,764.0
Төсөл/ сан			-
Төрийн сан			-
ТӨҮГ болон ОНӨҮГ	28,781.8	28,155.6	(626.2)
<b>Дүн</b>	<b>139,638.3</b>	<b>152,776.0</b>	<b>13,137.8</b>

Эх сурвалж: Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 1,848.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж, УТХО болон ОНТХО, хандив тусламж, үнэ төлбөргүйгээр 19,945.3 сая төгрөгийн, данс хооронд болон балансаас балансад 1,478.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө шилжүүлж, дахин үнэлгээний нэмэгдэл 107.9 сая төгрөг буюу үндсэн хөрөнгө нийт 23,379.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Холбогдох байгууллагын тушаал шийдвэрийг үндэслэн 1,514.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг актлан, 182.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний хорогдол, 1,420.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн нийт 3,118.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлээс хассан байна.

Дуусаагүй барилга дансанд 1,150.4 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаа бөгөөд ОНХС болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар тайлант онд хийгдэж дуусаагүй төсөл арга хэмжээний барилга байгууламжийг бүртгэж тайлагнасан байна.

#### Аудитын илрүүлэлт:

- Хатанбулаг сумын ЗДТГ нь 2019 онд Ай-Ти-Зоне ХХК-аас нийт 12.8 сая төгрөгийн 9 ширхэг зөөврийн компьютерыг шууд худалдан авч, үнийг 3 хуваан шилжүүлсэн байна. Энэ нь ХАА-ны хууль тогтоомжийг зөрчсөн байна.

#### 2.8.6 Урт хугацаат зээл

Урт хугацаат зээл дансны эхний үлдэгдэл 40.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 40.6 сая төгрөг болж, өөрчлөлт ороогүй байна.

#### Хүснэгт №6 Урт хугацаат хөрөнгө оруулалтын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт /+/-, бууралт /-/-
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон	40.61	40.61	-
<b>ДҮН</b>	<b>40.61</b>	<b>40.61</b>	<b>-</b>
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөл, сан			-
Төрийн сан	40.61	40.61	-
ТӨҮГ болон ОНӨҮГ			-
<b>ДҮН</b>	<b>40.61</b>	<b>40.61</b>	<b>-</b>

Эх сурвалж: Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урт хугацаат зээл дансны үлдэгдэл бүртгэлтэй 40.6 сая төгрөгийн зээл нь аймгийн  
өрөнхий орлогын тайланда бүртгэлтэй байх бөгөөд эзэн холбогдогч, ямар зориулалттай  
зээлийн авлага болох нь тодорхойгүй байна.

### 2.8.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн оны эхний үлдэгдэл 4,806.1 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 4,789.1  
сая төгрөг болж, 16.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №7 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
<b>Богино хугацаат өр төлбөр дүн</b>	<b>2,955.01</b>	<b>2,989.54</b>	<b>34.53</b>
Ажилчидтай холбогдсон өглөг	17.79	13.82	-3.97
Бараа үйлчилгээний зардлын өглөг	25.82	29.45	3.62
Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	34.13	-	-34.13
Байгууллагад төлөх өглөг	1,311.12	2,349.85	1,038.72
Хувь хүмүүст төлөх өглөг	10.98	1.77	-9.21
Төмөрчийн өглөг /ОНӨҮГ/ НДШ-ийн өглөг /ОНӨҮГ/	467.89 90.64	168.74 0.99	-299.15 -89.65
Дансны өглөг /ОНӨҮГ/	896.33	329.75	-566.59
Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого	71.76	37.84	-33.92
Бусад урьдчилж орсон орлого	28.54	15.58	-12.96
<b>Урт хугацаат өр төлбөр дүн</b>	<b>1,851.07</b>	<b>1,841.37</b>	<b>-9.7</b>
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөөв	1,841.37	1,841.37	-
Арилжааны банк	9.7	-	-9.7
<b>Нийт дүн</b>	<b>4,806.08</b>	<b>4,789.14</b>	<b>-16.94</b>
<b>Үүнээс, байгууллагын төрлөөр</b>			
Төсөвт байгууллага	1,937.92	1,584.99	(311.16)
Төсөл, сан	1.03	1.56	0.53
Төрийн сан	241.90	446.91	205.01
ТӨҮГ болон ОНӨҮГ	2,625.23	2,755.68	130.45
<b>ДҮН</b>	<b>4,806.08</b>	<b>4,789.14</b>	<b>-16.94</b>

Эх сурвалж: Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн 15.6 сая төгрөг нь ажилчидтай холбоотой, хувь  
хүмүүст төлөх өглөг, 29.4 сая төгрөг нь бараа үйлчилгээний зардлын өглөг, 2,349.8 сая  
төгрөг нь байгууллагад төлөх өглөг, 499.5 сая төгрөг нь ОНӨААН-ийн татвар, НДШ, дансны  
өглөг, 53.4 сая төгрөг нь урьдчилж орсон орлого байна.

Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний  
дуусаагүй ажлын 171.3 сая төгрөгийн санхүүжилтийг байршуулан, байгууллагад төлөх өр  
төлбөрөөр бүртгэж тайлагнасан байна.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдлийн 1,841.4 сая төгрөг нь Чандмань-Илч  
ОНӨХХК-ны данс бүртгэлд бүртгэлтэй МОН-1907 төсвийн хүрээнд хийгдсэн  
дамжуулан зээлдэх гэрээтэй холбоотой Азийн хөгжлийн банкнаас авсан урт  
хугацаат зээл байна.

### 2.8.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн гарын хувь оролцооны эхний үлдэгдэл 153,439.5 сая, эцсийн үлдэгдэл

169,131.0 сая төгрөг болж, 15,691.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7 Нийт өр төлбөрийн улдээдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт /+, бууралт /-/
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	47,194.13	51,086.27	3,892.14
Өмч /төрийн/ /ОНӨҮГ/ Эздийн өмчийн бусад хэсэг /ОНӨҮГ/	15,982.37	26,502.60	10,520.22
Хуримтлагдсан үр дүн Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	13,832.96 27,699.59 48,730.49	676.02 43,153.63 47,712.53	(13,156.94) 15,454.04 (1,017.96)
<b>ДҮН</b>	<b>153,439.53</b>	<b>169,131.04</b>	<b>15,691.50</b>
<b>Үүнээс, байгууллагын төрлөөр</b>			
Төсөвт байгууллага	122,178.64	136,531.86	14,353.22
Төсөл, сан	422.78	544.59	121.81
Төрийн сан	1,436.09	2,381.06	944.97
ТӨҮГ болон ОНӨҮГ	29,402.02	29,673.53	271.51
<b>ДҮН</b>	<b>153,439.53</b>	<b>169,131.04</b>	<b>15,691.51</b>

Эх сурвалж: Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын сангийн хувь оролцооны 80.7 хувь буюу 136,531.7 сая төгрөгийг төсөвт байгууллага, 0.3 хувь буюу 544.6 сая төгрөгийг төсөл сангуд, 1.4 хувь буюу 2,381.1 сая төгрөгийг төрийн сангуд, 17.5 хувийг 29,673.5 сая төгрөгийг орон нутгийн өмчит хуулийн этгээд тус тус эзэлж байна.

## 2.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 14 төсвийн төвлөрүүлэн захирагч 125 төсвийн байгууллага, 6 төрийн өмчит аж ахуйн нэгж, 30 тусгай сан нийт 175 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 171 байгууллага аудитад хамрагдаж, 4 байгууллагад итгэл үзүүлсэн байна.

Аудитаар төсөв захирагчийн 66 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 105 тайланд дүгнэлт гаргалаа. Үүнд:

- Зөрчилгүй санал дүгнэлтийг 87 төсөв захирагчид
- Хязгаарлалттай санал дүгнэлтийг 17 төсөв захирагчид /Алтанширээ сумын ТТЗ, Дэлгэрэх сумын ТТЗ, Сайхандулаан сумын ТТЗ, Хатанбулаг сумын ТТЗ, Хөвсгөл сумын ТТЗ, Айраг сумын ЕБС, Алтанширээ сумын ЕБС, Дэлгэрэх сумын ЗДТГ, Улаанбадрах сумын ЕБС, Хатанбулаг сумын ЗДТГ, Хөвсгөл сумын ЗДТГ, Замын-Үүд сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэг, Замын-Үүд сумын Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэг, Сайншанд сумын ЕБ-ын 1 дүгээр сургууль, Сайншанд сумын ЕБ-ын 4 дүгээр сургууль, Сайншанд сумын Хүүхдийн 7 дугаар цэцэрлэг, Эрдэнэ сумын Дагшин-Эрдэнэ ОНӨХХХ/
- Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан дүгнэлтийг 1 тайланд /Нийтлэг үйлчилгээний газар/ өглөө.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 207,447.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлсэнээс 202,065.3 сая төгрөгийн алдааг запруулж, 52.7 сая төгрөгийн зөрчилд 40

төлбөрийн акт тогтоож, 388.7 сая төгрөгийн зөрчилд 57 албан шаардлага хүргүүлж, 4,941.2 сая төгрөгийн зөрчилд 235 зөвлөмж өглөө.

Хязгаарлалттай санал дүгнэлт авсан 18 албан тушаалтанд Төрийн аудитын тухай хуулийн 28.2.1-д заасны дагуу хариуцлага тооцуулахаар нийт 11 албан шаардлагыг холбогдох дээд шатны төсөв захирагч нарт хүргүүллээ.

#### Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн запруулга

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн, давхардсан бичилтийг устгаагүй, ажил гүйлгээ үлдэгдлийг зөрүүтэй тайлagnасан байна. Үүнд:

- Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайланд 165.1 сая төгрөгөөр мөнгөн хөрөнгийг дутуу, авлагыг 433.6 сая төгрөгөөр илүү, урьдчилгаа төлбөрийг 908.1 сая төгрөгөөр дутуу, бараа материалыг 0.7 сая төгрөгөөр дутуу, үндсэн хөрөнгийг 680.1 сая төгрөгөөр дутуу, өр төлбөрийг 1,445.4 сая төгрөгөөр дутуу нэгтгэсэн;
- Санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайланд санхүүжилтийн орлогыг 1,297.1 сая төгрөгөөр илүү, үйл ажиллагааны зардлыг 25,130.2 сая төгрөгөөр дутуу нэгтгэсэн;
- Нэгтгэсэн цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайланд 127.8 сая төгрөгөөр тайлант үеийн үр дүнг илүү нэгтгэсэн;
- Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд санхүүжилтийн орлогыг 917.9 сая төгрөгөөр илүү, нийт зарлагыг 910.6 сая төгрөгөөр илүү нэгтгэсэн;
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд нийт зарлагыг 26,199.6 сая төгрөгөөр илүү, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 26,182.3 сая төгрөгөөр илүү нэгтгэсэн;
- Төсвийн ерөнхийлөн захирагч болон харьяа байгууллага хооронд үүссэн 98,696.8 сая төгрөгийн давхардсан авлага, өр төлбөр, орлого болон зардлын давхардсан ажил гүйлгээний устгах бичилтийг дутуу тайлagnажээ.
- Аймгийн хөрөнгө оруулалтаар тайлант онд бүрэн хэрэгжсэн, хэрэгжиж дуусаагүй, урьдчилгаа санхүүжилт олгосон ажлын гүйцэтгэлийг санхүүгийн тайланд дутуу тайлagnасан, мөн өмнөх оны авлага өглөг барагдаагүй байхад данс бүртгэлээс хассан зэрэг 3,506.6 сая төгрөгийн алдаа байна.
- Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн дүнг, ТТЗ, аймгийн төвийн ТШЗ-ын болон ОНӨААН-ийн аудит хийгдсэн санхүүгийн тайлантай тулган баталгаажуулахад Дагшин Эрдэнэ ОНӨААН нь санхүүгийн тайланд 10.1 сая төгрөгөөр зөрүүтэй тайлagnасан байна.

#### Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар

Төсвийн төвлөрүүлсэн захирагчийн 14 нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгсөн. Үүнд:

- Зөрчилгүй санал дүгнэлт- 9,
- Хязгаарлалттай санал дүгнэлт- 5 / Алтанширээ сумын ТТЗ, Дэлгэрэх сумын ТТЗ,  
Сайхандулаан сумын ТТЗ, Хатанбулаг сумын ТТЗ, Хөвсгөл сумын ТТЗ /

Аудитаар нийт 10,361.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 10,308.5 сая төгрөгийн алдааг запруулж, 53.1 сая төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өглөө.

Хязгаарлалттай санал дүгнэлт авсан 5 төсвийн төвлөрүүлэн захирагчид хариуцлага тооцуулах санал хүргүүллээ.

#### Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа төсвийн 125 байгууллагаас 4 байгууллагаад итгэл үзүүлж, 37 байгууллагын санхүүгийн тайлант түүвэрт хамруулж, 84 байгууллагын тайланд санал дүгнэлт өглөө. Үүнд:

- Зөрчилгүй санал дүгнэлтийг-73 байгууллагад,

- Хязгаарлалттай санал дүгнэлтийг -11 байгууллагад /Айраг сумын ЕБС, Алтанширээ сумын ЕБС, Дэлгэрэх сумын ЗДТГ, Улаанбадрах сумын ЕБС, Хатанбулаг сумын ЗДТГ, Хөвсгөл сумын ЗДТГ, Замын-Үүд сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэг, Замын-Үүд сумын Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэг, Сайншанд сумын ЕБ-ын 1 дүгээр сургууль, Сайншанд сумын ЕБ-ын 4 дүгээр сургууль, Сайншанд сумын Хүүхдийн 7 дугаар цэцэрлэг/

Аудитаар нийт 5,529.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 2,417.7 сая төгрөгийн алдааг залруулж, 52.5 сая төгрөгийн зөрчилд 39 төлбөрийн акт тогтоож, 94.0 сая төгрөгийн зөрчилд 28 албан шаардлага, 2,964.7 сая төгрөгийн зөрчилд 192 зөвлөмж өглөө.

Хязгаарлалттай санал дүгнэлт авсан 8 албан тушаалтанд хариуцлага тооцуулах саналыг холбогдох дээд шатны албан тушаалтнуудад хүргүүллээ.

#### Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа орон нутгийн өмчит 6 аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайланд санал дүгнэлтийг өгсөн. Үүнд:

- Зөрчилгүй санал дүгнэлт - 4,
- Хязгаарлалттай санал дүгнэлт - 1 /Эрдэнэ сумын Дагшин-Эрдэнэ ОНӨ ХХК/,
- Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан 1 /Нийтлэг үйлчилгээний газар/

Аудитаар нийт 194.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 47.9 сая төгрөгийн алдааг залруулж, 0.2 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 2 албан шаардлага 146.6 сая төгрөгийн зөрчилд 30 зөвлөмж өглөө.

Хязгаарлалттай санал дүгнэлт авсан 2 албан тушаалтанд хариуцлага тооцуулах саналыг холбогдох дээд шатны албан тушаалтанд хүргүүлсэн болно.

#### Тусгай санд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа тусгай сангийн 30 тайлангаас 1 сангийн тайланд санал дүгнэлт өгч, 29 сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан. Үүнд:

- Зөрчилгүй санал дүгнэлт - 1

Аудитаар нийт 3,122.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 2,679.1 сая төгрөгийн алдааг залруулж, 294.7 сая төгрөгийн зөрчилд 27 албан шаардлага, 148.4 сая төгрөгийн алдаа, зөрчилд 6 зөвлөмж өглөө.

Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн болон хариуцлага тооцуулах санал гараагүй болно.

#### **2.10. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БЮОУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ**

Аймгийн ТЕЗ-ийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгөн шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

#### **2.11. Шилэн дансны мэдээлэл**

Дорноговь аймгийн ТЕЗ-ийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 138 мэдээллийг хугацаанд нь, 12 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл, Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл, Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, Аудитын тайлан, дүгнэлт,

зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан гэх мэт мэдээллүүдийг хуулийн хугацаанд байршуулсан байна.

## 2.12. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх онд нийт 4 зөвлөмж өгснөөс 3 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй буюу зөвлөмжийн хэрэгжилт 75 хувьтай байна. Үүнд:

- **Өгсөн зөвлөмж:** Аймгийн ИТХ, Замын-Үүд сумын ИТХ-ын нөөц хөрөнгө нэрээр зарцуулагдаж байгаа зардлыг ангилан, тухайн шатны төсвийн зарлагад хамаарах Төсвийн эдийн засгийн ангиллын дагуу төлөвлөж, зарцуулах.

Мөн Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2016 санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар өгсөн зөвлөмжөөс 1 зөвлөмж хэрэгжээгүй байна. Үүнд:

- **Өгсөн зөвлөмж:** Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сан нэрээр хувийн хэвшлийн аж ахуй нэгжид олгосон зээлийн дансанд байрших 60.0 сая төгрөг, хандивын сан нэрээр байгууллагаас авах авлага дансны эзэн холбогдогч тодорхойгүй 21.0 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах, авлагыг барагдуулах арга хэмжээ авах

## 2.13. ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

### “Зөрчилгүй” санал дүгнэлт

Залруулагдаагүй 1,628.4 сая төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон 1,692.6 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс 64.2 сая төгрөгөөр бага тул зөрчилгүй санал дүгнэлтийг өгч байна.

Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

## 2.14. Аудитын зөвлөмж

### 1. Аудитын тайлантай холбоотой

**1.1 Илрүүлэлт:** Дорнговь аймгийн ТЕЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 14 төсвийн төвлөрүүлэн захирагч 125 төсвийн байгууллага, 6 төрийн өмчит аж ахуйн нэгж, 30 тусгай сан, нийт 175 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн.

Дээрх төсөв захирагчдын санхүүгийн тайланд илэрсэн 1,193.7 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил нь ТЕЗ-ийн тайланд нөлөөллөө.

### 1.2 Эрсдэл:

Аймгийн ТЕЗ-ийн аудитын дүгнэлтэд нөлөөлөх

### 1.3 Өгсөн зөвлөмж:

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд илэрсэн зөрчлийг бууруулах, давтан гаргахгүй байхад чиглэсэн бодлогын арга хэмжээ авч ажиллах

### 2. Нягтлан бodoх бүртгэлтэй холбоотой

**2.1 Илрүүлэлт:** Аудитаар илэрсэн 186,612.1 сая төгрөгийн бүртгэлийн алдаа нь Төрийн сангийн бүртгэлтэй холбоотой байна. Аудитын явцад санхүүгийн тайлanguудыг зөрүүтэй бэлтгэсэн, аймгийн ОНХС, аймгийн хөрөнгө оруулалтын ажил гүйлгээнүүдийг буруу бүртгэж тайлагнасан, давхар бичилтүүдийг устгаагүй, аудит хийгдсэн санхүүгийн тайланг зөрүүтэй нэгтгэсэн зэрэг зөрчил илэрсэн бөгөөд дээрх алдааг аудитын явцад залруулах бичилт хийлгэлээ.

Энэ нь Үнэлгээ ба Үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна, Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-д “Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх зарчмыг хэрэгжүүлэхэд санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бodoх бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах”, Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.4-т “төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээр өмчийн оролцоотой аж ахуйн нэгж” улсын секторын НББ-ийн стандартыг заавал мөрдөнө”, 14 дүгээр зүйлийн 14.3.2-т “Нягтлан бodoх бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааны журналд бичих”, 14.3.3-т “Нягтлан бodoх бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааны дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “Нягтлан бодогч холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бodoх бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бodoх бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах үүрэгтэй”, Сангийн сайдын 2006 оны 388-р тушаалын 1.2-т “Төсөвт байгууллага НББ хөтлөх, нийтлэг зориулалт бүхий санхүүгийн тайланг бэлтгэж гаргахад энэхүү зааврыг мөрдөнө” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

**2.14.2.2 Эрсдэл:** Санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэн гаргахгүй байх, хэрэглэгчдийг үнэн зөв мэдээллээр хангахгүй байх эрсдэлтэй

### 2.14.2.3 Өгсөн зөвлөмж:

Аймгийн Төрийн сан, ОНХС, хөрөнгө оруулалтын санхүүгийн үйл ажиллагаанд нягтлан бodoх бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг

журналд бичин, дэлгэрэнгүй болон өрөнхий данс хөтлөн санхүүгийн тайланг үнэн зөв гаргаж байх, тус зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Дорноговь аймгийн Төрийн аудитын газарт 2020 оны 9 дүгээр сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

